

*Н.Наранцогт - Хууль сахиулах удирдлагын академийн
8042 дугаар дамжааны сурацагч*

*В.Пүрэвбаасан -Хилийн албаны удирдлага стратегийн
профессорын багийн дэд профессор, хурандаа*

ХАР ТАМХИ, МАНСУУРУУЛАХ БОДИСТОЙ ТЭМЦЭХЭД ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, ТҮННИЙ УДИРДЛАГА

Хураангуй. Энэхүү нийтлэлээр хар тамхи, мансууруулах бодис илэрсэн үед хил хамгаалах байгууллага ямар үүрэгтэй оролцох удирдлагын твшинд хэрхэн удирдах талаар гаргаж тавихыг зорилоо.

Түлхүүр үг. Хар тамхи мансууруулах бодис Хил хамгаалах байгууллага хар тамхи, мансууруулах бодисыг илрүүлэх, хил зүрчигч, ачаа бараанд үзлэг хийх удирдлага зохион байгуулалт.

Монгол Улсын хэл зүйн тайлбар толь бичигт “Хар тамхи” гэдэг нь хатааж хэмхчин боловсруулаад, татах үнэрлэхэд бэлэн болгосон, хүүний дотор тодорхойгүй болох, мансуурах гэж талбарласан байна.

Мансууруулах түрлийн бодис гэдэг нь байгальд зэрлэг байдлаар ургадаг олсны ургамал, намуу цэцэг, мексикийн мүүг, кокийн бут зэргийг хамруулан ойлгох бөгүүд эдгээр мансууруулах үйлчилгээтэй түрхий эдийг химийн урвалд оруулах, нийлэгжүүлэх буюу синтетик хэлбэрт оруулснаар цэвэр кокайн, герион буюу дэлхий нийтээр хэлж хэвшсэн “Хар тамхи”-ыг гарган авдаг. Бусад хар тамхи, мансууруулах бодисын бүх түрлүүдийг дээрх кокайн, героиноос гарган авдаг ба түннээс гаргаж авсан бусад бодисоор анагаах ухаанд олон түрлийн тайвшруулах, үвчин намдаах зэрэг эм, тариа үйлдвэрлэдэг байна.

Мансууруулах бодис нь хүүний уураг тархи, мэдрэл сэтгэхүүд хүүтэй хор нүүлүү үзүүлдэг химийн болон ургамлын гаралтай бодис юм.

Мансууруулах бодис хэрэглэх нь мансуурах, донтох, сэтгэлийн гаж хүүрүүлд орох, гуньж гутрах зэргээр сэтгэл мэдрэлийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулна.

Дэлхий нийтээрээ мансууруулах бодисыг Наркотик гэж нэрлэж байгаа ба хүүшүүх, мэдээ алдуулах, мансууруулах, нойрсуулах гэсэн утгатай грек үг.

Үндсэн хэсэг: Мансууруулах бодисыг хэрэглэдэг хоёр шалтгаан байна:

Хүүнд үвчтүүнд зайлшгүй шаардлагатай гэж үзсэн тохиолдолд (маш хүүнд хагалгаа, хорт хавдрын үед г.м) эмчийн хяналтын дор, эмнэлгийн нүүхүүлд хэрэглэдэг.

Нэг нь хор уршгийг нь мэдэхгүйгээс бусдад уруу татагдах, бусдыг ухамсаргүйгээр дуурайх, сонирхож саваагүйтэх, сэтгэлийн хямралаас гарах гэж эрсэнээс болж хууль бус хэрэглэдэг.

УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4.4.1-д "Иргэдийн терроризм, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хэчирхийллээс хамгаалагдах нөхцөлийг сайжруулна" гэж, 3.4.4.3-т "Мансууруулах, сэтгэцэд нөлүүлэх бодисын эргэлтэд хяналт тавих, хууль бус хэрэглээтэй тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлнэ" гэж, 3.4.4.4-т "Нийгэмд эдгээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаархи сургалт, сурталчилгааг эрчимжүүлж, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлнэ" гэж, Засгийн газрын 2016-2020 оны Үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.4.3-т "Мөнгө угаах, хэний наймаа, хар тамхины болон цахим гэмт хэрэг зэрэг шинэ төрлийн гэмт хэргийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ" гэж тус тус заасан.¹

Монгол Улс Мансууруулах бодисын тухай 1961 оны конвенцид 1990 онд, Сэтгэцэд нөлүүт бодисын тухай НҮБ-ын 1971 оны конвенцид 1999 онд, Мансууруулах бодис ба сэтгэцэд нөлүүт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны конвенцид 2001 онд, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг НҮБ-ын конвенцид 2008 онд тус тус нэгдэн орсон бөгөөд мансууруулах болон сэтгэцэд нөлүүт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр олон улсын өмнө зорьго хариуцлага хийлээдэг.

Монгол Улсын төр мансууруулах бодисын талаарх олон улсын санал, санаачилга болон зорьго, зорилтыг хангахын төлөө хэчин чармайлт гаргаж ирсэн бөгөөд 2002 онд Мансууруулах эм, сэтгэцэд нөлүүт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийг баталж, 2002 онд баталсан Эрүүгийн хуульд дээрх төрлийн гэмт хэрэгт хийлээлгэх хариуцлагыг бий болгож, 2000-2005 онд "Хар тамхи, мансуурахтай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлсэн.

НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх алба (UNODC)-ны тайланд Америк болон Баруун Европын улс орнуудад каннабисийн, Алс болон Ойрхи дорнод, Зүүн өмнөд Азийн улс орнуудад амфетамин, синтетик төрлийн хар тамхины хэрэглээ, илдвэрлэл ихээр нэмэгдэж, зах зээл өргөжиж байгаа талаар дурджээ. Түүнчлэн уг тайланд хөгжиж байгаа болон буурай хөгжилтэй орнуудын эдийн засаг, хууль, эрх зүйн болон бусад сул талыг нь ашиглан зохион байгуулалттай бөглөг, гэмт бөглөглөл "д мансууруулах ^{1 2}

¹ Мансууруулах эм, сэтгэцэд нөлүүт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол.

/ <http://www.legalinfo.mn/annex/details/7692?lawid=12557>

² Мөн тогтоол.

бодисын нийлвэрлэлээ дээр дурдсан улс орнуудад шилжүүлэн байрлуулж байгааг онцлон тэмдэглэсэн байна.

Дэлхийн 127 орны цагдаагийн болон хар тамхитай тэмцэх албаны оролцсон “Ндэстэн дамнасан хар тамхи мансууруулах сэтгэгдэл нийлүүлэгч бодисын хууль бус эргэлт, мөнгө угаахтай тэмцэх асуудал нь дэлхий нийтийн тулгамдсан асуудал болох нь” сэдэвт ээлжит 33 дугаар хурлын нэгдүгээр илтгэлд тэмдэглэсэн тоон мэдээгээр сүүлийн жилүүдэд 40 орчим шинэ нэр төрлийн мансууруулах болон сэтгэгдэл нийлүүлэгч бодис бүртгэгдсэн, эдгээрээс молекулын бүтцийг тодорчлэх замаар химийн урвалд оруулсан “Плакка”, “Молли” гэх ургамлын гаралтай бодис дэлхий даяар хурдацтай тархаж байгаа гэжээ.

Европын холбооны улс орнуудад метамфетамин агууламж бүхий мансууруулах бодис, кокаин, героин, Азид ICE буюу метамфетамин агууламж бүхий мансууруулах бодис, героин, кокаин, Төв азид каннабисийн хэрэглээ өсч, улмаар хууль бус нийлвэрлэл болон эмийн хэрэглээ нэмэгдсээр байна. Хүн худалдаалах, мансууруулах бодис наймаалах, нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, галт зэвсэг, тэсэрч дэлбэрэх бодис, төлх соёлын дурсгалт зүйлсийн хууль бус эргэлт, терроризм, хууль бус цагаачлал, зохион байгуулалттай бүлэг, гэмт бүлэглэл байгуулах гэмт хэргүүд байнга нийлдэгдэх болж, тэдгээрийн санхүүгийн эх үүсвэрийг мансууруулах болон сэтгэгдэл нийлүүлэгч бодисын хууль бус эргэлтээс олдог бохир мөнгө бүрдүүлдэг байна.¹


Сүүлийн жилүүдэд БНХАУ, ОХУ болон Зүүн Азийн орноос амфетамин, метамфетамин төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг манай хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон ба цагдаа, хил, гаалийн байгууллагаас ирүүлсэн мэдээллээр БНХАУ-аас ихэвчлэн амфетамин, метамфетамин төрлийн мөс (ICE) болон мансууруулах ургамлын гаралтай шавар (Hashish), ОХУ-аас сэтгэгдэл нийлүүлэгч анданте зэрэг эм хууль бусаар нийлүүлэх болжээ.

Монгол Улсад мансууруулах эм, сэтгэгдэл нийлүүлэгч бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн нийцүүл байдлыг 2006-2016 оны байдлаар хийснэгтээр үзүүлбэл:

¹ Мансууруулах эм, сэтгэгдэл нийлүүлэгч бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоол.

<http://www.legalinfo.mn/annex/details/7692?lawid=12557>

**2006-2016 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, үйлдэл, холбогдогчийн тоог
хүснэгтээр үзүүлбэл:**



Гадаад харилцааны яамнаас ирүүлсэн мэдээллээр манай улсын иргэд 2006 оноос хойших байдлаар: БНХАУ-д 94, ОХУ-д 5, Казахстанд 3, Германд 1, Малайзад 5, Унгарт 3, Бангладешт 3, Грект 1, Болгарт 1, Словак улсад 1 нийт 117 хүн хар тамхи, мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт холбогдон шалгагдсанаас тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн тус тус шүүхээс ял шийтгэгдсэн байна. Үүнээс торгуулийн ял шийтгэгдсэн 6, баривчлах ял шийтгэгдсэн 10, нас барсан 2, тодорхой хугацаантай хорих ял шийтгэгдсэн 42, хугацаагүй хорих ял шийтгэгдсэн 5, цаазын ял шийтгэгдсэн 7, хэрэг нь хэрэгсэхгүй болсон 7, 2016 оны байдлаар 9 хэрэгт 9 иргэн холбогдон шалгагдсан байна.¹

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бэхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг бөгөөд түүнийг механик аргаар устгахад 1 га талбайд гарах зардлыг 53,300 төгрөг, химийн аргаар устгахад 40,300 төгрөг тус тус байхаар холбогдох мэргэжлийн байгууллагаас тооцон гаргасан боловч төсөв, санхүүгийн байдлаас шалтгаалан дээрх төрлийн ургамлыг устгах ажил хангалтгүй хийгдэж ирсэн.

Монгол Улсад: Хар тамхи, мансууруулах бодисыг хууль бусаар Монгол Улсын хил нэвтрүүлсэн бол таваас дээш арван жил хэртэл хугацаагаар хорих ялаар, энэ хэргийг давтан буюу бэлэглэж, урьдчилан үгсэж тохиролцсон бэлэг, эсхүл их хэмжээтэйгээр, түүнчлэн албан тушаалтан албан тушаалынхаа байдлыг ашиглаж үйлдсэн бол арваас дээш хорин жил хэртэл

¹ ЦЕГ-ын гэмт хэрэг, зөрчлийн сангийн мэдээлэл.

хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэнэ гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20.7.1; 20.7.2-т заасан байдаг.¹

Бүлэг зохион байгуулалттайгаар үйлдсэн, насанд хүрээгүй хүнийг хар тамхи, мансууруулах бодис хэрэглэхэд татан оролцуулсан, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, тээвэрлэсэн, хилээр нэвтрүүлсэн бол ОХУ-ын эрүүгийн хуульд 10-20 жил хүртэлх хугацаагаар хорих ялаар, БНХАУ-д 15 жил хүртэл хугацаагаар хорих, хугацаагүй хорих, цаазаар авах хүртэл ял шийтгэдэг байна.

Тиймээс иргэд энэ түрлийн гэмт хэргийн хор аюулыг сайтар ойлгож, энэ аюулаас хүн бүр өөрийгөө хамгаалж ангид байхыг Эрүүгийн цагдаагийн албаны Хар тамхитай тэмцэх газраас зөвлөж байна.

Монгол улсын хэмжээнд хар тамхи хэрэглэгчдийг дараах 4 ангилалд хамааруулан авч үздэг.

Эхний бүлэгт: чинээлэг айлын хүмүүд ордог ба тэд ихэвчлэн БНХАУ-ын хилээр хууль бусаар их хэмжээгээр нэвтрүүлэн оруулж ирдэг гашиш болон синтетик түрлийн хар тамхи, амфетамин, мансууруулах бодис хэрэглэж зуршсан байна.

Хоёрдох бүлэгт: - "хип хоп" урсгалын дуу хүгжим сонсдог залуучууд, дуучид гашиш болон зэрлэг үвсийг хольж хэргэлдэг.

Гурав дах бүлэгт: - рок дуу, хүгжим сонирхдог залуучууд бусад ангилалд байгаа хүмүүсийг бодвол хамгийн боломж муутай хэрэглэгч гэж тооцогддог тэд ихэвчлэн Монгол Улсын нутагт ургадаг хар тамхины түрлийн ургамлыг түлж, бэлтгэх, улмаар түлшнийгээ хатааж боловсруулан татах байдлаар хэрэглэж мансуурсан тохиолдлууд цөөнгүй бүртгэгдсэн байдаг.

Дөрөв дэх ангилалд Монгол Улсад түр болон удаан хугацаагаар оршин сууж байгаа гадаадын иргэд орох бүгдэд тэд хоёрдугаар ангиллын хүмүүстэй адил хэрэглээтэй байдаг.

2015 оны 9 сараас өмнө ХХЕГ-ын Хилийн тагнуулын газар, ЦЕГ-ын Эрүүгийн цагдаагийн газар хамтран улсын хилээр хар тамхи, мансууруулах бодис хууль бусаар нэвтрүүлж буй үйлдэлтэй тэмцэж байсан.

Дээрх хамтын ажиллагааны хүрээнд Хилийн тагнуулын газар 2011 онд хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллаж хар тамхи, мансууруулах бодисыг дангаарай 10 гаруй зөрчил, хамтран 20 орчим зөрчлөлийг илрүүлсэн байна.

Жишээ нь: 2013 оны аравдугаар сарын 30-ны өдөр Дорноговь аймгийн Замын-Ууд дэх авто замын шалган нэвтрүүлэх боомтоор Монгол Улсын иргэн “Б” гэгч БНХАУ-аас хар тамхи, мансууруулах бодис оруулж ирж байгаа талаар мэдээлэл ирсний дагуу шалгалт явуулжээ.

¹Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20,7,1; 20.7.2-т заасан.

Мэдээллийн мөрөөр Монгол Улсын иргэн Б гэгчийг саатуулан шалгахад “Marlboro” тамхины хайрцагт 0.976 грамм ICE буюу Мос гэх мансууруулах бодис илчлэгтэй бодис авч явсныг илрүүлэв.¹

Монгол Улсын иргэн “Б” нь БНХАУ-ын Эрээн хотоос хар тамхийг тосон авч Замын-Уд дэх авто замын шалган нэвтрүүлэх боомтоор дамжуулан Улаанбаатар хотод хэргэх үүрэгтэй “тээвэрлэгч” байсан.

Энэхүү хэрэгт Хилийн тагнуулын тасгаас арваннэгдүгээр сарын 03-ны 10-р хойшлуулашгүй ажиллагаа явуулж сум дундын прокурорт хянуулахад тухайн хэрэг нь хэнд гэмт хэрэгт тооцогдох учир Нийслэлийн прокурорт шилжүүлэхээр болсон байна. Тиймээс Улаанбаатар хотын харьяат “Б” гэгчийг ЭЦГ-ын Хар тамхитай тэмцэх хэлтсийн ажилтнууд нийслэлд хуяглан авчирсан байна. Тус этгээдэд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 20,7,1; 20,7,2-т зааснаар эрүүгийн хэрэг үүсгэсэн. Холбогдогч “Б” нь ашиг олох зорилгоор дээрхи мансууруулах бодисыг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхийг завдсан. Дээрхи этгээдийг ШШГЕГ-ын харья 461-р хорих ангид цагдан хорих, таслан сэргийлэх арга хэмжээ авсан.

Харилцан ажиллагаа, мэдээлэл солилцох

Монгол Улсын хил нэвтэрч буй зорчигч, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж буй эрх бүхий байгууллагууд дараах хэлбэрээр харилцан ажиллаж, мэдээ мэдээлэл солилцож болно.

Олон улсын чанартай Буянт-Ухаа, Замын-Уд, Сүхбаатар, Алтанбулаг боомтуудад: Хилийн хяналт шалгалтын бүсэд үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжийн ажилтан, албан хаагчдаас албан үүрэг гүйцэтгэх явцад илэрсэн улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон зөвлөлийн талаар; хил зорчигчийг илрүүлэн саатуулж, биед эзлэг хийх явцад хар тамхи, мансууруулах бодис илэрсэн үед; боомтод эрх бүхий байгууллага тусгай арга хэмжээ явуулж буй үед сэжигтэй зорчигчийн талаар мэдээлэл солилцох, хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангах, судалгаа хийх боломжийг бүрдүүлж, боомтын хөдөлгөөнийг хязгаарлана.

Хамтын ажиллагааны давуу ба сул тал

Давуу тал. Хил хамгаалах байгууллагаас цагдаа, тагнуулын байгууллагуудтай байгуулсан тушаал, гэрээ. төлөвлөлийн талаар чиглэл үгч, доод шатанд шуурхай хамтран ажиллах нөхцөл бүрдсэн.

- Хилийн отрядуудын штаб нь тухайн орон нутгийн аймаг, сумдын цагдаагийн газар, хэлтсүүдийн эрүүгийн тасагтай хамтран газар орон дээр буюу автозам, тэмцээм, агаарын замын боомтуудад тухайн хамтын

¹ <http://bpo.gov.mn/news/dailynews/1311140002/detail>

ажиллагааны тушаал. тлвлгний дагуу ажиллах дадлага сургуулийг хийж тодотгосон.

- Гарсан хилийн зрчил. тээврийн хэрэгсэлд хар тамхи. мансууруулах бодис илэрсэн ед хууль сахиулах байгууллагуудаас хамтран эрэн сурвалжлах ажиллагаа явуулах практик туршлага болсон бгд хамтарсан ажиллагааны р дн дээшилсэн.

Сул тал. Хилийн тухай хууль болон холбогдох эрх зйн актуудад нарийн тодорхой тусгагдаагй.

Тухайн хар тамхи тээвэрлэгч. хэрэглэгчийг илрлэн саатуулсан хилчдийн амь нас, ар гэрийг хамгаалсан эрх зйн зохицуулалт¹ байхгй учир иргээд илрлсэн албан хаагчдад ямар нэгэн байдлаар эрсдэлд орох магадлал ндр байна.

- Улсын хил, боомтод хар тамхи, мансууруулах бодисыг илрлэх боломж байгаа боловч, алба хаагчдын хувьд энэ трлийн гэмт хэргийг илрлэх дадлага, туршлага бага.

- Шалгагч нарын хар тамхитай холбоотой мэдээлэл, тухайн сэжигтэнийг улсын хилээр нэвтрэх ед саатуулах арга тактик, дадлага сул.

ДГ ГНЭЛТ:

1. Хилийн тагнуулын газар нь Хил хамгаалах байгууллагын бтцэд байхдаа хар тамхи, сэтгэцэд нллх бодис тээвэрлсэн болон хэрэглэсэн хмсийг илрлж, саатуулан хууль зйн дагуу шийдвэрлэж байсан бол, тагнуулын байгууллагын тухай хуульд рчллт орсонтой холбогдуулан Хил хамгаалах байгууллага хар тамхи, мансууруулах бодисыг илрлэх боломжтой ч хэн хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгй болсон,

2. Хар тамхины хэрэг бол хамгийн нууцлал ндртэй, ял ндртэй хэрэг. Хилчид тухайн хэргийг илрлсэн тохиолдолд эсрэг талаас срг йлдэл хийх магадлал маш ндр. Хар тамхийг тээвэрлэж байгаа этгээдийг илрлсэн албан хаагчдад эрсдэл учрах магадлал ндр,

3. Зрчлийн хэлбэр нийгмээ дагаад улам боловсронгуй, ндр зохион байгуулалттай болж байгаа бгд хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг улам боловсронгуй болгох, холбогдох байгууллагуудын эрх зйн орчныг сайжруулах шаардлагатай гэж дгнэж байна.

4. Судалгааны ажлын хрээнд звхн эд зйлийг хууль бусаар нэвтрлэх зрчлийн чиг хандлага гэж явцууралгй Хил хамгаалах байгууллагын эрх зйн тогтолцооны нгийн байдал. байгууллагын твшний эрсдэлийн удирдлагын тогтолцоо гэсэн хамгийн гол ндэс суурь болсон йл ажиллагааны хрсэн р днг хамруулан судалсан. нд:

¹ Монгол улсын Хилийн тухай хууль. //Трийн мэдээлэл. УБ. 2017. № 25.

- Хууль эрх зүйн орчинг бүрдүүлж, нэгдсэн бодлого, стратеги төлөвлөгөөг боловсруулан, байгууллагын төвшний эрсдэлийн удирдлагын тогтолцоог гарган ирэхийн тулд ажиллаж байгаа;
- Гадаад орнуудын туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохируулан хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн, Хэрш болон Цагдаа, Тагнуул. Гаалийн байгууллагуудтай зөрчлийн мэдээлэл солилцох гм.
- Зөрчлийн мэдээллийн нэгдсэн цахим сантай болж, төвндээ эрсдэл тооцон ажилласан;
- Төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагааг эхлүүлэх гэх мэт.

Дэвшүүлэх санал:

- Гүйцэтгэх ажлыг эрчимжүүлэх, хил хамгаалах байгууллагад гүйцэтгэх ажил явуулах эрхийг буцаан сэргээснээр сүүлийн нөд гарч буй гэмт хэрэг, хилийн зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, илрүүлэлт нэмэгдэх
- Хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх оновчтой бодлогыг тууштай хэрэгжүүлж, хамтын ажиллагааны өр дөнг дээшлүүлэх, шаардлагатай хөрөнгө мөнгө, тоног төхөөрөмжийг шийдэн, хар тамхитай тэмцэх чиглэлээр мэргэшсэн боловсон хүчинг бэлтгэх, чадварлаг багийг бий болгох.

Г.Цогбадрах - Хууль сахиулахын удирдлагын академийн
8021 дүгээр дамжааны суралцагч, дэд хурандаа
Я.Ариунболд - Хилийн албаны удирдлага, стратегийн
профессорын багийн профессор, хурандаа

ХИЛИЙН ТӨЛӨӨЛГЧИЙН АЛБАНЫ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЗАРИМ АСУУДАЛ

Хураангуй. Энэхүү илтгэлээр Монгол Улсын Хилийн төлөөлөгч, төлөөний үйл ажиллагааны эрх зүйн нөдэслэл, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийж, цаашид хилийн төлөөлөгчийн албаны удирдлага, зохион байгуулалтад анхаарах зарим асуудлын талаар хөндхийг зорьсон болно.

Төлхөөрө г. Хилийн төлөөлөгч, эрх зүйн нөдэс, удирдлага, зохион байгуулалт, түлгэмдсан асуудал.

Хилийн төлөөлөгч гэдэг нь хилийн асуудлаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээг улсын хилийн тодорхой хэсэгт хэрэгжүүлэх, хилийн зөрчлөхс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг шийдвэрлэх чиглэл рэг бөхий Монгол Улсын хилийн төлөөлөгч /цаашид “хилийн төлөөлөгч”